

## МЭИ, МУИС, СЭЗИС, ШУТИС, ХААИС, АШУУИС

### ФИЛОСОФИ, ХҮНИЙ ЭРХИЙН УУЛЗВАРТ: “ЗҮЙ ЁС БА ХҮНИЙ ЭРХ”

#### Философийн XIII улсын олимпиадын удирдамж

Хүн төрөлхтний мэдлэг улам бүр тэлж, техник технологийн хэрэглээ нэмэгдэж буйн хэрээр ёс зүй, улс төр, эрх зүйн хувьд шийдэл хүлээсэн олон асуудал тулгарч байна. Тэдгээрийн дотор нийгэм, улс төр, бизнесийн хүрээнд хүний эрхийг хүндэтгэн, зүй ёсыг хангаж ажиллах, шийдвэр гаргах шаардлага үндэсний төдийгүй олон улсын түвшинд гарч ирж байна. Нийгмийн олон салбарт нийгмийн бүлгүүдийн тэгш бус байдлыг анхаарах, хүний эрхийн зөрчлийг арилгах зэрэг чухал асуудалд философи, хүний эрх үүднээс хандаж, зүй ёсыг эрэлхийлэх хэрэгцээ бидний өмнө байна. Иймээс **Философи, Хүний эрхийн уулзварт XIII олимпиадаа “ЗҮЙ ЁС БА ХҮНИЙ ЭРХ”** сэдэвт чиглүүлэн оюутан залуусын ухааны цэцийг сориход зориулж байна.

“Зүй ёс”-ны тухай асуудал бол философийн түүхийн нэн эртнээс өнөө цаг үе хүртэл сэтгэгчдийн дунд хэлэлцэгдэж, нийгмийн амьдралд холбогдож ирсэн асуудлын нэг юм. Орчин үед энэ чиглэлд томоохон дискурс өрнүүлсэн философич Ж.Роулс нэгэнтээ “*Үнэн* гэсэн ойлголт сэтгэлгээний системд хэр зэрэг байр суурь эзэлдэг шиг *зүй ёс* гэсэн ойлголт нийгэм-улс төрийн системд мөн тийм байр эзэлдэг” хэмээн тэмдэглэсэн буй. Иймээс улс төрийн философийн сонгодог онолууд, либерализм, марксизм, зүй ёсны онолын үүднээс оюутан залуус орчин үеийн нийгмийн амьдралын олон асуудалд философи эргэцүүлээр оролцох юм.

#### Дэд сэдэв:

1. Бизнес ба зүй ёс
2. Тэгш байдал ба зүй ёс

**Хамрах хүрээ:** Монгол Улсын бүх их, дээд сургуульд философийн хичээл судалж буй оюутнууд оролцож болно.

#### Үр дүн:

1. Олимпиадад оролцогч оюутнуудад дараах ач холбогдолтой.
  - Бизнес, тэгш байдлын асуудлыг философийн үүднээс харж, нийгмийн амьдралын олон асуудал хүний оюун ухаан, сэтгэл зүй, ёс суртахуунд холбогдож байдгийг судлан эргэцүүлнэ.
  - Бизнесийн үйл ажиллагаанд хүний эрхийг хангах хэрэгцээ шаардлагыг философийн үзэл баримтлалд тулгуурлан тайлбарлах чадвараа хөгжүүлнэ.
2. Философийн мэдлэгийн хэрэглээ, үнэ цэнийг ойлгуулахад дэмжлэг үзүүлнэ.

**Олимпиадын хэлбэр:** Цахим талбараар зохион байгуулна.

#### Олимпиадын даалгавар:

1. Сэдэвт хамаарах фото зургийн даалгавар гүйцэтгэнэ.
2. Философийн сорилд хариулна.

3. Философийн эх бичиг, эсвэл кино бүтээлээс философи утга санааг тунгааж тайлбарлана.

4. Философи, хүний эрхийн асуудлаар тохиолдол жишээ шинжилнэ.

**Шалгаруулалт:** Багуудыг 2 үе шаттай шалгаруулна.

*I шатны шалгаруулалт:*

#	Гүйцэтгэх даалгавар	Тайлбар	Агуулга	Шүүгчээс авах оноо
1	Фото зураг бэлтгэх /2 ширхэг/	-Өгөгдсөн сэдэвт холбогдох фото зураг бэлтгэж, бүртгэлийн мэдүүлгийн хамт илгээнэ. -Олимпиадын үеэр нэг гишүүн нь зургийнхаа санааг ярьж танилцуулна.	Бизнес ба зүй ёс, Тэгш байдал ба зүй ёс	25 оноо
2	Тест ажиллах /10 мин/	-Философийн агуулгаар 25 тестийг гишүүн тус бүр бөглөж, дундаж оноогоор дүгнүүлнэ.	Философийн ерөнхий мэдлэг	25 оноо

*II шатны шалгаруулалт:*

#	Гүйцэтгэх даалгавар	Тайлбар	Агуулга	Шүүгчээс авах оноо
1	Кино хэлэлцүүлэг	Мэргэжлийн судлаачдаас санал болгосон кинонд задлан шинжилгээ хийх, үндэслэлээ дэвшүүлэх	Бизнес ба зүй ёс, Тэгш байдал ба зүй ёс	25 оноо
2	Тохиолдол шинжилгээ	Мэргэжлийн судлаачдаас санал болгосон хэд хэдэн кейсээс сугалж, задлан шинжилгээ хийх	Бизнес ба зүй ёс, Тэгш байдал ба зүй ёс	25 оноо

**Дүгнэх журам:**

**Эхний шалгаруулалт:** I шатны 2 даалгаврын гүйцэтгэлийн нийлбэр оноогоор жагсааж, II шатанд үлдэх шилдэг багуудыг шалгаруулна.

**Эцсийн шалгаруулалт:** II шатанд кино хэлэлцүүлэг, тохиолдол шинжилгээ хийсэн оноог нэгтгэж, эцэслэн шалгаруулна.

**Ерөнхий зохион байгуулалт:**

- Олимпиадыг ZOOM, MOODLE /Зөвхөн тестийг энэ талбараар/ талбараар хослуулан цахим байдлаар зохион байгуулна.
- Философийн хичээл орж буй багш нар багаа бэлтгэн оролцуулна.
- Нэг их, дээд сургуулиас 5 хүний бүрэлдэхүүнтэй зөвхөн нэг баг оролцоно.
- Багийн гишүүдийн хоёр нь уг олимпиадад өмнө нь 1 удаа оролцсон оюутан байж болно. Уг оюутан нь 2 дугаар курсийн оюутан байна.

**Байр, шагнал:**

Багийн шагнал:

- I байр - 1: Өргөмжлөл, мөнгөн шагнал
- II байр – 1: Өргөмжлөл, мөнгөн шагнал
- III байр - 1: Өргөмжлөл, үнэ бүхий зүйл
- IV байр - 1: Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

Оролцогчдын шагнал:

Уран илтгэгч - 1: Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

Мэргэн санаа дэвшүүлэгч- 1: Өргөмжлөл, үнэ бүхий зүйл

**Бүртгэл:**

Дараах материал, баримтыг бүрдүүлж, цахимаар илгээнэ. Үүнд:

1. Бизнес ба зүй ёс, тэгш байдал ба зүй ёсны зөрчлийг илэрхийлсэн 2 фото зураг
2. Олимпиадад оролцох багийн нэр, гишүүдийн овог нэр, оюутны үнэмлэхийн эх-хуулбар, сургуулийн цахим шуудан, холбоо барих утасны дугаарын мэдээллийг нэгтгэж, мэдүүлэг илгээнэ.

**Мэдүүлгийг**

2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 17:00 цагаас өмнө

[humanity@ufe.edu.mn](mailto:humanity@ufe.edu.mn) хаягт багийн ахлагч илгээнэ.

**Олимпиад:** 2021 оны 12 дугаар сарын 2-ны Пүрэв гарагт 08.45-17.30 цагт ZOOM, MOODLE талбараар зохион байгуулагдана.

**Үндсэн зохион байгуулагч:** Монголын Эмнести Интернэшнл, МУИС, СЭЗИС, ШУТИС, ХААИС, АШУҮИС

**Холбоо барих хаяг:**

Зохион байгуулах ажлын хэсэг: Б.Мөнхзул /99209077/ [Munkhzul.b@ufe.edu.mn](mailto:Munkhzul.b@ufe.edu.mn)

Б.Тэргэл /96504440/ [tergel.batnyam@amnesty.mn](mailto:tergel.batnyam@amnesty.mn)

**Хавсралт:** Фото зурагт тавигдах шаардлага:

- Бизнес ба зүй ёс, тэгш байдал ба зүй ёс сэдэвт холбоотой фото болон зурсан зураг, эвлүүлэг, эсвэл шог зураг байж болно.
- Зургийн нэр, товч тайлбар эсвэл уриаг баруун доод хэсэгт сургуулийнхаа логоны хамт 4\*10 см хэмжээтэй хүрээнд байрлуулсан байна.
- Урьд нь олны хүртээл болоогүй зураг байна.
- Өгөгдсөн хэмжээ шаардлагын дагуу бэлтгэнэ.

